БАТЛАВ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГА Д.СҮХЭЭ

**ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХҮРЭЭНД 2021 ОНД АВЛИГА, ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

**2021.02.24**

| № | Зорилго | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хүрэх үр дүн |
|---|---|---|---|
| **Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх, ёс зүйг дээшлүүлэх** | | | |
| 1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх. | 1.1.Хууль тогтоомжид заасны дагуу албан тушаалд томилогдох албан тушаалтны Хувийн ашиг сонирхлын урьдчилан мэдүүлгийг АТГ-ын Дүн шинжилгээний хэлтэст хянуулж, томилох. | Албан тушаалтныг томилогдохдоо Хууль, тогтоомжийн дагуу ХАСУМ гаргуулж томилсон байна. |
| | | 1.2.Төрийн захиргааны болон үйлчилгээний удирдах, албан тушаалтнуудын хөрөнгө орлого, ашиг сонирхлын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүлээн авч АТГ-т тайлан, нэрсийг хуулийн хугацаанд хүргүүлэх. | Хууль тогтоомжийн хэрэгжилт сайжирна. |
| | | 1.3.АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон сурталчилгааны самбар, лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах. | Баримтжуулж, үр дүнг тооцож, тайлагнах. |
| | | 1.4.ЭМГ-ын сайтад Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлын тайланг цахим хуудсанд байршуулж, иргэдийг мэдээллээр хангах боломж нөхцлийг бүрдүүлэх. | Цахим болон веб сайтанд байршуулсан байна. |
| | | 1.5. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдэнд үйлчилгээ үзүүлж буй бүх түвшний мэргэжлийн болон захиргааны байгууллага, албан тушаалтнуудад зориулсан урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт зохион байгуулах. | Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлийн мэдээллээр хангагдаж, сургалт зохион байгуулагдсан байна. |
| 2 | Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуур болон албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дээшлүүлэх | 2.1.Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулах. | -Холбогдох хууль журмын дагуу томилж, дэвшүүлсэн байх<br>-Шинээр томилогдох нийтийн албан тушаалтныг хувийн ашиг сонирхлын урьдчилан мэдүүлгийг хянуулсны дараа томилсон байх. |
| | | 2.2. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчил, өргөдөл, гомдлыг судалж тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх. | Өргөдөл, гомдлын программын бүртгэл утга, агуулга, шийдвэрлэлтээрээ ангилагдан бүрэн бүртгэгдэж хэвшсэн байна. |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах. | 3.1.Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, ААНБ болон гадаадын хандив, зээл тусламжийн ил тод байдлыг хангаж ажиллах. | Иргэдэд ойлгомжтой хүртээмжтэй байдлаар хүргэж ажиллах. |
| 4 | Хяналт хариуцлага, үр ашгийг нэмэгдүүлэх. | 4.1.Тендерийн үнэлгээний хороонд ажиллаж байгаа ажилтнуудын ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлэх мэдэгдлийг тогтмол авч хэвших. | Үнэлгээний хорооны гишүүд ашиг сонирхлын зөрчилгүй байна. |
| | | 4.2.Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын үйл ажиллагааг идэвхижүүлэх, хяналт шалгалтын ажлыг төлөвлөх, дүнг мэдээлэх, илэрсэн зөрчилд хариуцлага тооцох, шалгалтын мөрөөр тодорхой арга хэмжээг авч ажиллах. | Хяналт, хариуцлагын тогтолцоо сайжирна |